



СҮҮ БОНД

- ▶ Хугацаа: 1 жил
- ▶ Хүү: 17.5%
- ▶ Хэмжээ: 6.0 тэрбум төгрөг
- ▶ Нэрлэсэн үнэ: 100 000 төгрөг
- ▶ Захиалга: 2017/06/22-29

“СҮҮ БОНД”-ЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

"Сүү" ХК-ийн гаргаж буй өрийн хэрэгслийг олон нийтэд нээлттэй арилжихтай холбогдуулан тус үнэт цаасны захиалга авах үйл ажиллагаа 2017 оны 6 дугаар сарын 29-нийг дуустал явагдах бөгөөд андеррайтер компанийн зүгээс 2017 оны 06 сарын 23, 27-ны өдрүүдэд 11:00-16:00 цагийн хооронд "Сүү" бонд-ын танилцуулах өдөрлөгийг Монголын хөрөнгийн биржийн байранд зохион байгуулж байна.

Тус үнэт цаасны андеррайтераар "Голомт капитал ҮЦК" ХХК ажилласан ба туслах андеррайтераар "Тэнгэр капитал ҮЦК" ХХК, "Ард капитал ҮЦК" ХХК-иуд ажиллаж байна.

Өрийн хэрэгслийн мэдээлэл:

Үндэслэл:	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 6-р сарын 19-ний өдрийн А/108 тоот тушаал, СЗХ-ны 2017 оны 6-р сарын 22-ны 129 тоот тогтоол
Үнэт цаасны нэр	“Сүү” бонд
Нэгж бондын нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Нийт тоо, ширхэг	60,000 ширхэг
Нийт үнийн дүн	6,000,000,000 төгрөг
Бондын хугацаа /хоног/	365
Бондын жилийн хүү	17.50%
Хүү төлөх хугацаа	Хугацааны эцэст нэг удаа
Бондын эргэн төлөлтийн хэлбэр	Хугацааны эцэст нэрлэсэн үнээр

Тус бондыг захиалахыг хүсвэл андеррайтер компаниудтай холбогдоно уу.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ